



**АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН
НУТАГТ ОРШИХ “ДЭНЖ” ЭЛС ХАЙРГАНЫ
ХОЛИМГИЙН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАН
БЕТОН ЗУУРМАГ ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН 2023
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

*Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-65000035 (2022/001А)
Регистрийн дугаар: 3014231*

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГазрын мэргэжилтэн..... Х.Дулмаа

Архангай аймгийн БОАЖГазрын мэргэжилтэн..... Б.Солонго

Биелэлтийг тайлагнасан:

“Ашид бэхи” ХХК-ийн захирал:..... П.Болортуяа

“Ашид бэхи” ХХК-ний байгаль орчны мэргэжилтэн Н.Гончигмаа

Агуулга

1. ОРШИЛ	5
2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	5
3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	14
3.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	14
3.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	18
3.3. Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт	20
4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	22
5. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	27
6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	28
7. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	28
8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	29
9. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	30
10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	31
11. ДҮГНЭЛТ	33

Зургийн жагсаалт

Зураг 1 Талбайн байршлын зураг	6
Зураг 2 Хайрга бутлуурын үйлдвэр.....	8
Зураг 3 Бетон зуурмагийн үйлдвэр.....	8
Зураг 4 Бетон боловсруулалтын явц.....	9
Зураг 5 Ил уурхай болон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэсгийн байршил	9
Зураг 6 Ажилчдын хотхон орчмын төлөв байдал	10
Зураг 7 Оффисын байр.....	11
Зураг 8 Ажилчдын шал тогоо.....	11
Зураг 9 Усалгааны ажил хийгдэж буй байдал	15
Зураг 10 Тоосжилтийг бууруулах зорилгоор хучилт хийж буй байдал	16
Зураг 11 Тоосжилтыг бууруулах зорилгоор элс тээврийн машины ачаанд хучилт хийж буй байдал	17
Зураг 12 Агаарын хэмжилт хийж буй байдал.....	17
Зураг 13 Ундны ус болон, Ахуйн бохир уснаас дээж авч буй байдал.....	19
Зураг 14 Худгийн тоолуур, баталгаажуулалт	19
Зураг 15 Ахуйн бохир ус соруулж буй байдал	20
Зураг 16 Замын болон зогсоолын тэмдэг тэмдэглэгээ хийсэн байдал	21
Зураг 17 Шимт хөрсний овоолгоноос дээж авч буй байдал.....	21
Зураг 18 Техникийн нөхөн сэргээлт хийгдсэн талбай	23
Зураг 19 Техникийн нөхөн сэргээлтийн явц.....	23
Зураг 20 Техникийн нөхөн сэргээлт хийгдсэний дараа	24
Зураг 21 Мод тарилтын явц.....	26
Зураг 22 Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн явц.....	27
Зураг 23 Хог хаягдлыг ялган ангилах хогийн сав	29

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбилцол	6
Хүснэгт 2 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт.....	14
Хүснэгт 3 Усан орчны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт.....	18
Хүснэгт 4 Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт.....	20
Хүснэгт 5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө болон биелэлт	28
Хүснэгт 6 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө болон биелэлт	30
Хүснэгт 7 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө болон биелэлт	31
Хүснэгт 8 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн нийт зардал	32

Хавсралтын жагсаалт

Хавсралт 1 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл.....	36
Хавсралт 2 Хаягдал усны дүгнэлт	39
Хавсралт 3 Ус ашиглах дүгнэлт.....	44
Хавсралт 4 Усны төлбөр төлсөн баримтууд.....	44
Хавсралт 5 Ахуйн бохир ус соруулах гэрээ.....	45
Хавсралт 6 Газар эзэмших гэрчилгээ	46
Хавсралт 7 ОХШ-ний хөтөлбөрт ажил гүйцэтгэх гэрээ	48
Хавсралт 8 Агаарын шинжилгээний дүн	49

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭНЖ” ЭЛС, ХАЙРГАНЫ
ХОЛИМГИЙН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАН БЕТОН ЗУУРМАГ ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН 2023
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Хавсралт 10 Усны дээж шинжилгээний дүн.....	50
Хавсралт 11 Хөрсний шинжилгээ дүн	51
Хавсралт 12 Агаарын шинжилгээний дүн	52
Хавсралт 13 Хог хаягдал гэрээ]	54

1. ОРШИЛ

Манай компани нь байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах, байгалийн унаган төрхийг аль болох хадгалах, байгаль орчны бодлого зорилтод нийцсэн арга хэмжээнүүдийг авч, биелэлтийг ханган ажиллахыг зорьж ажилладаг. Үүнд:

- ☆ Байгаль орчны бохирдолтоос сэргийлэх, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах сөрөг нөлөөллийг тодорхойлж, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг авах зорилгоор байгаль орчны хяналт шинжилгээнийхөтөлбөрийг хийлгүүлэх
- ☆ Байгаль орчныг хамгаалах тухай хууль, тогтоомж холбогдох дүрэм журам стандартыгдагаж ажиллах
- ☆ Олборлолт болон уурхайн үйл ажиллагааны бүхий л үе шатанд байгаль орчны асуудлыг тусган хэрэгжүүлэх хамаарна.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан нь тус оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний заалтуудыг ханган ажиллахад чиглэсэн болно.

2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: “Ашид бэхи” ХХК

Төслийн зорилго: “Дэнж” элс-хайрганы холимгийн ордоос олборлосон элс-хайрганы холимгийг бутлан ангилаж бетон зуурмаг үйлдвэрлэн сайн чанарын бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлж борлуулахад чиглэнэ. Хангайн нурууны салбар уулс хөв цагаан нурууд, уудам тал хээр хосолсон нутагтай. Урьд талаараа Баян-Овоо, баруун талаараа Бөмбөгөр, Заг, хойт талаараа Жаргалант, зүүн талаараа Эрдэнэцогт, Архангай аймгийн Их тамир, Булган, Чулуут сумтай тус тус хил залгана.

Төслийн байршил: “Дэнж” элс-хайрганы холимгийн орд нь Архангай хотоос 480 км, Архангай аймгаас зүүн урагш 5.0 км, Эрдэнэбулган сумаас зүүн урагш 2 км зайд оршино.


- ✓ Ордын нэр: “Дэнж”
- ✓ Засаг захиргаа: Архангай аймаг, Эрдэнэбулган сум
- ✓ Ашигт малтмалын үндсэн төрөл: Элс-хайрганы холимог
- ✓ Тусгай зөвшөөрлийн талбайн планшит: М-47-024

Орд ашиглах тусгай зөвшөөрөл: 37.41 га талбай бүхий ашигт малтмалын 2022/001А дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдөр “Ашид бэхи” ХХК-д олгосон байна.

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭНЖ” ЭЛС, ХАЙРГАНЫ ХОЛИМГИЙН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАН БЕТОН ЗУУРМАГ ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хүснэгт 1 Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбилцол

Д /д	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	Сек
1	101	30	59.29	47	26	58.55
2	101	30	45.43	47	26	55.13
3	101	30	45.43	47	27	22.0
4	101	31	18.89	47	27	22.0



Зураг 1 Талбайн байршлын зураг

Ордын мэдээлэл: Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 5-р багийн нутагт орших “Дэнж” элс-хайрганы холимогийн ордыг ил аргаар ашиглах төсөл нь 5 жилийн хугацаанд үргэлжлэх ба бодитой В боломжтой С зэрэглэлээр бодогдсон геологийн нөөц нь 561.57 мян.м³ элс-хайрганы холимог байна. Ордын магадласан (В') үйлдвэрлэлийн нөөцөөр 356.12 мян.м³ элс-хайрганы холимог олборлоно. Тус ордын ил уурхайн хүчин чадлыг жилд 75.0 мян.м³ элс-хайрганы холимог олборлохоор техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан байна.

Шимт хөрсийг хуулж стандартын дагуу овоолгод хураахаар тооцсон ба уурхайн хөрс хуулалт, элс-хайрганы олборлолтын хэмжээг тогтмол барьж ашиглалт явуулна.

Хүний нөөц, ажлын горим: Тус төсөл нь 1 ээлжээр ажиллах ба ээлжийн үргэлжлэх хугацаа 10 цаг байна. Тус төслийн хүрээнд 30 хүн ажиллах ба 03 дугаар сараас 11 дүгээр сарыг дуустал тасралтгүй ажиллах бөгөөд жилд 189 хоног ажиллана. Дэнж элс-хайрганы холимгийн уурхай нь Цэцэрлэг хоттой ойр байрлах тул хүний нөөц, ажилчдын чадавхи өндөр, дэд бүтэц сайн хөгжсөн зэрэг давуу талуудтай байна. Иймд уурхайн ажилчид болон инженер техникийн ажилтныг Цэцэрлэг хотоос авч ажиллуулахаар төлөвлөсөн бөгөөд ажилчид уурхайд байрлаж ажиллахгүй.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэл: “Ашид бэхи” ХХК-ийн бүтээгдэхүүн үйлвэрлэлийн хэсэг нь бутлан ангилах хэсэг болон бетон зуурмагийн үйлдвэр гэсэн 2 хэсгээс бүрдэх бөгөөд Дэнж элс-хайрганы холимгийн ордоос 3.8 км-ын зайд байрлана. Бутлан ангилах хэсэг болон бетон зуурмагийн үйлдвэр нь нэг дор байрлах бөгөөд Дэнж элс-хайрганы холимгийн ил уурхайгаас олборлосон элс, хайргыг автосамосвалаар тээвэрлэн бутлан ангилах хэсэгт түр овоолгод овоолж байна.





Зураг 2 Хайрга бутлуурын үйлдвэр



Зураг 3 Бетон зуурмагийн үйлдвэр



Зураг 4 Бетон боловсруулалтын явц

Бутлан ангилах хэсэг: Бутлан ангилах хэсгийн эцсийн бүтээгдэхүүн нь ширхэгээр ангилсан элс, хайрга гарах бөгөөд бетон зуурмагийн үйлдвэрийн түүхий эд болгон ашиглаж М350 маркийн бетон үйлдвэрлэж байна.



Зураг 5 Ил уурхай болон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэсгийн байршил



Зураг 6 Ажилчдын хотхон орчмын төлөв байдал





Зураг 7 Оффисын байр



Зураг 8 Ажилчдын шал тогоо

Байгаль орчны төлөв байдал

Физик газарзүй, газар нутгийн онцлог: Хангайн уулархаг мужийн төв хэсэгт оршдог. Хангайн нурууны салбар уулс, ойт хээр, тал хээрийн бүсээс бүрддэг. Далайн төвшнөөс дээш 2414м өндөрт өргөгдсөн, хамгийн өндөр цэг нь Харлагтайн сарьдаг 3539м, хамгийн нам дор газар нь Орхон-Тамирын бэлчир 1290м. Нутгийн баруун, баруун өмнө, өмнө хэсэгт далайн төвшнээс дээш 2400-3500м өндөрт өргөгдсөн Хангайн нуруу болон түүний салбар уулс, баруун хойд хэсэгт 3000 гаруй м-ийн өндөр Тарвагатайн нуруу орших бөгөөд зүүн, зүүн хойд, зүүн өмнө талаараа далайн төвшнээс дээш 1000-1500 м-ийн өндөртэй уулс, голын хөндий эзэлсэн тал хээртэй.

Газарзүйн байрлал: Дэнж элс-хайрганы холимгийн орд нь Улаанбаатар хотоос 480 км, Архангай аймгаас зүүн урагш 5.0 км, Эрдэнэбулган сумаас зүүн урагш 2 км зайд оршино.

Уур амьсгал, агаарын чанар: Архангай аймгийн Эрдэнэбулган сум нь уур амьсгалын мужлалтын хувьд чийглэгдүү хүйтэвтэр зунтай, хахир өвөлтэй мужид хамаардаг. Агаарын дундаж температур -0.7°C орчим байх бөгөөд 1-р сарын дундаж температур -19°C , 7-р сарын дундаж температур $+15^{\circ}\text{C}$ байна. Жилд дундажаар 300-350 мм хур тунадас унах ба үүний 60% болон түүнээс дээш хувь нь зуны улиралд унана. Тогтвортой цасан бүрхүүл 11-р сараас эхлэн тогтох бөгөөд дундажаар 120 орчим өдөр үргэлжилнэ. Цасны дундаж зузаан нь 20-25 см байх боловч хунгарласан газартаа 40 орчим см хүрнэ. Салхитай өдрийн тоо жилд 20 хоногоос бага бөгөөд салхины чиглэл ихэвчлэн баруун хойноос 2.6-3.5 м/сек байна.

Усан орчин: Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутаг нь Хойд мөсөн далайн ай савд багтана. Төсөл хэрэгжих талбай нь Орхон голын сав газарт хамаарна. төслийн талбай нь Орхон голын сав газарт орж байна. Орхон гол нь Сэлэнгэ мөрний хамгийн том цутгал бөгөөд Хангайн нурууны салбар уулс Суварга хайрхан уулын өвөр бэлээс эх авсан Их тээл гол, түүний цутгал гол болох Өлт голыг Орхон голын эх гэж үздэг. Гол нь эхэн хэсэгтээ уулархаг, доошлох тусам дов толгод зонхилсон дунд зэргийн уулархаг гадаргаар, цаашлаад тал хээр, уулсын хөндийгөөр урсана. Хөндийдөө хүрмэн чулуун гүн хавцалтай, адагтаа гол өргөсөж олон салаа болдог.

Тус голын сав газрын хамгийн өндөр цэг нь 3539,9 метр өргөгдсөн Анггархай уулын оргил байхад хамгийн нам цэг нь Орхон гол Сэлэнгэ мөрөнд цутгах хэсэгт 601.1 метр байна. Орхон голын сав газар нь Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Хангайн мужид багтаж байгаа ба голын эхэн хэсэг нь Хангайн гол нурууны тойрогт, дунд ба адаг хэсэг нь Сэлэнгэ, Орхоны сав газрын дундаж өндөр уулсын тойрогт хамрагдаж байна.

Хөрсөн бүрхэвч: Монгол орон газарзүйн байршлын хувьд Дорнод Сибирийн цэвдэгт тайгаас Төв Азийн хуурай цөлд шилжих завсрын нутгийг эзлэх тул байгалийн нөхцөлийн ялгаа маш эрс тэс, нөгөө талаар гадаргын төрх байдал жигд биш өндөр нам уул нуруу, хотос хонхор, ухаа гүвээ, хяр толгод, хөндий хоолой, нүд алдам тал газар хосолсон учраас хөрсөн бүрхэвчийн бүтэц, бүрэлдэхүүн ихээхэн ярвигтай, олон янзын өвөрмөц маягийн хөрс үүсэж, хөгжих нөхцөл бүрджээ.

Ургамлан нөмрөг: Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутагт орших “Дэнж” элс-хайрганы холимгийн орд нь экосистемийн хувьд Ойт хээрийн экосистемд багтана. Тус талбай нь Монгол орны ургамал газарзүйн мужлалтаар Евро-Азийн шилмүүст ой, нуга хээрийн их мужийн Чийглэг хэв шинжийн Төв хангайн умард өндөр уулын мужид хамаарна. Монгол орны төв хэсэг болох Хангайн уулархаг бүс нутгаас ба баруун хойноос зүүн урагш чиглэсэн, уртаараа 600 орчим км, хойш Хөвсгөл нуур хүртэлх өргөн уудам нутгийг хамаарна.

Амьтан: Хангайн тойрогт өндөр уул, ойг хээр, хээрийн бүсийн амьтад тохиолдох тул зүйлийн бүрдлийн хувьд баялаг юм. Баавгай, зэрлэг гахай, бор гөрөөс, буга, аргаль, янгир, ирвэс, чоно, үнэг, хярс, мануул, дорго, шилүүс, туулай, чандага, тарвага, цагаан болон хар сүүлт зээр зэрэг баялаг ан амьтантай.

3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Ашид Бэхи” ХХК нь байгалийн нөөцийг ашиглаж, үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд оршин буй нутгийн байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагааныхаа нэг хэсгийг чиглүүлэх үүрэгтэй. Нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм, эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл, эрсдэлийг тооцон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тогтоогдсон ажлуудыг цаг тухай бүрд зардлыг төсөвлөн зайлшгүй авах арга хэмжээнүүдийг дагаж ажиллаа.

3.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хүснэгт 2 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт

№	Төлөвлөгөө	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Засгийн газрын 2018 оны 379 дүгээр тогтоолоор батлагдсан “Тусгай зориулалттай авто зам, замын байгууламж барих, ашиглах журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах	Уурхайн ашиглалтын инженер, үйлдвэрийн дарга	Үйлдвэр уурхай хоорондох замыг сайжруулан засаж тэмдэг тэмдэглэгээ хийсэн.
2.	Зам арчилгааны зардал		Автозам ба овоолго, ажлын талбайг тогтмол усан, засч, тэгшилж ажилласан.
3.	Олборлолтын үед тоосжилт ихээр үүсэхээс сэргийлж тогтмол усалгаа хийх, салхи ихтэй үед тоос багасгах арга хэмжээ авах	Үйлдвэрийн дарга, Байгаль орчны мэргэжилтэн	Уурхайгаас үйлдвэр явах технологийн замд элс тээврийн машины ачаанд хучилт хийх, бутлуураас гарсан бүтээгдэхүүнийг хучих замаар тоосжилтыг бууруулах арга хэмжээ авч байсан.
4.	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө.		Тээврийн хэрэгслийн төлбөр, татварыг бүрэн төлж ажилласан.
5.	Агаарын тоосны (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээ мэргэжлийн байгууллагаар хийлгэх		Хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан агаарын шинжилгээг хийлгэсэн ба шинжилгээний дүнг хавсаргав.
6.	Хүнд механизмууд, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг байнга хийж, утааны яндангаас гарах хорт хийн хэмжээг стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байх		250 мот/цаг тутамд тээврийн хэрэгслүүдийн тос, маслыг сольж байсан. Тээврийн хэрэгслийн төлбөр, татварыг бүрэн төлж ажилласан.



Зураг 9 Усалгааны ажил хийгдэж буй байдал



Зураг 10 Тоосжилтийг бууруулах зорилгоор хучилт хийж буй байдал



Зураг 11 Тоосжилтыг бууруулах зорилгоор элс тээврийн машины ачаанд хучилт хийж буй байдал



Зураг 12 Агаарын хэмжилт хийж буй байдал

3.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, БОМТөлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ундны ус, ахуйн бохир уснаас дээж авч тус тус лабораторид шинжлүүлэв

Хүснэгт 3 Усан орчны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт

№	Төлөвлөгөө	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх	Байгаль орчны мэргэжилтэн	Шинжилгээний хариу шалгуур үзүүлэлт нь хавсралтад тусгагдав.
2.	Унд ахуйн усанд эрүүл ахуй болон хамгаалалтын бүсийг тогтоох		Унд ахуйн усанд эрүүл ахуй болон хамгаалалтын бүсийг тогтоож, тухайн бүсэд мөрдөх журмыг сахин ажилласан
3.	Уст цэгт тоолуур байрлуулан, баталгаажуулах		Уст цэгт тоолуур байрлуулан баталгаажуулан ашигладаг.
4.	Ахуйн бохир усыг ил задгай асгахгүй байх, орчны бохирдол үүсэхээс сэргийлж хуримтлуулах, бага оврын цэвэрлэх байгууламж суурилуулж цэвэршүүлж ногоон байгууламж, нөхөн сэргээлтийн усалгаанд ашиглах		Ахуйн бохир усыг орон нутагтайгаа гэрээ байгуулан тусгай зориулалтын машинаар соруулж орон нутгийн төвлөрсөн байгууламжид хүргүүлж байна.
5.	Шатах тослох материал алдагдах үед урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах		Шатах тослох материалаас алдагдах үед авах зааварчилгаа гарган ажилчдад сургалт зохион байгуулсан.



Зураг 13 Ундны ус болон, Ахуйн бохир уснаас дээж авч буй байдал



Зураг 14 Худгийн тоолуур, баталгаажуулалт

Унд ахуйн усанд эрүүл ахуй болон хамгаалалтын бүсийг тогтоож, тухайн бүсэд мөрдөх журмыг байгууллагын хэмжээнд боловсруулан ажилчдад танилцуулан ажилласан бөгөөд Цэвэр усны микробиологийн шинжилгээний үр ундны ус нь стандарт хэмжээнд байна.



Зураг 15 Ахуйн бохир ус соруулж буй байдал

3.3. Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт

Хүснэгт 4 Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт

№	Төлөвлөгөө	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Газар эзэмших гэрээгээ сумын засаг даргатай байгуулах, төлбөрөө төлөх	Үйлдвэрийн дарга	Газрын гэрчилгээг хавсаргав.
2.	Тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар явуулахыг хориглосон таних тэмдэг бүхий самбаруудыг байрлуулах, сайжруулах.	Байгаль орчны мэргэжилтэн	Технологийн замдаа тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан..
3.	Шатах тослох материалын хадгалалтанд хяналт тавьж ажиллах, шатах тослох материал алдагдсан тохиолдолд цаг тухай бүрт нь саармагжуулах арга хэмжээ авах	Байгаль орчны мэргэжилтэн	Хамгаалах талбайг бэлтгэн, асгаралтын үед шаардагдах элс, шингээгч материалуудыг ойр байршуулсан.
4.	Өнгөн хөрсийг хуулан авах, уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө болон түүний явцад хуулан авсан өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгалах.		Шимт хөрсийг стандартын дагуу хуулах, хадгалах ажлыг зохион байгуулсан. Шимт хөрсний овоолгоос дээж авч лабораторид шинжлүүлсэн.



Зураг 16 Замын болон зогсоолын тэмдэг тэмдэглэгээ хийсэн байдал

Хөрснөөс дээж авахдаа бид талбайн ерөнхий шинжийг илтгэж чадахуйц цэгүүдээс зохих маршрутын дагуу явж дээж авдаг. Тус шинжилгээгээр хөрсний ялзмаг, хөрсний рН, хүнд металлуудыг үзүүлж биологийн нөхөн сэргээлт хийхэд анхаарах зүйлс болон хөрсний ялзмаг, нөхөн сэргээлтэнд бордоо ашиглах зэрэг олон талын мэдээллүүдийг авах боломжтой болдог.



Зураг 17 Шимт хөрсний овоолгоноос дээж авч буй байдал

4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутагт хэрэгжих Дэнж элс-хайрганы холимгийн ордыг ил аргаар ашиглах төслийн ТЭЗҮ-д 6 дахь жилд нөхөн сэргээлтийн ажлыг хийхээр төлөвлөсөн байна.

Техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 0.4 га талбайд хийхээр төлөвлөөд байсан бол **1.0 га** талбайд техникийн нөхөн сэргээлт хийж, биологийн нөхөн сэргээлтийн ажил төлөвлөгөөгүй болно.

Цөлжилтөөс хамгаалах ойн тухай хуулийн дагуу, “Тэр бум мод” хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрийн орчинд орон нутгаас 5 төрлийн 500 ш модыг суулгаж арчилгаа, усалгааны ажлыг гүйцэтгэж байна. Орчноо сайхан харагдуулах өнгө үзэмж сайтай навчаараа, жимсээрээ, мөчрөөрөө, цэцгээрээ гоёдог гоёлын болон жимсний моднуудыг сонгосон. Суулгахдаа нутгийн иргэдийг болон ажилчдаа оролцуулан мэргэжлийн хүний зөвлөгөөтэйгээр мод хоорондын зай, мөр хоорондын зай, мод тарих тогооны хэмжээ, усалгаа арчилгаа гэх мэтээр ажилчдад давхар модтарих бодит сургалт болсоноороо илүү давуу талбай байлаа.

Цаашдын арчилгаа чухал байдаг учраас мод болон хашаан доторх зүлгээ арчлах усалахжил дээр тусгайлан цэцэрлэгч томилон ажиллуулж байна.



Зураг 18 Техникийн нөхөн сэргээлт хийгдсэн талбай



Зураг 19 Техникийн нөхөн сэргээлтийн явц



Зураг 20 Техникийн нөхөн сэргээлт хийгдсэний дараа

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭНЖ” ЭЛС, ХАЙРГАНЫ
ХОЛИМГИЙН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАН БЕТОН ЗУУРМАГ ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН 2023
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**





Зураг 21 Мод тарилтын явц

5. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Их Тамир сумын хуучин элсний талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн.



Зураг 22 Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн явц

6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023 оны олборлолтын явцад ямар нэгэн түүх, соёлын дурсгалт зүйл олдоогүй болно.

7. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгальд хаягдах хаягдлын хэмжээг багасгахын тулд эх үүсвэр дээр нь ялган ангилалт хийх хогийн савыг уурхайн хотхон байрлуулан, ялган ангилалт хийж, ажилчдад хог хаягдлын хор уршиг болон ялган ангилалтын үр ашгийн талаарх сургалтуудыг орсон.

Үйл ажиллагааны явцад гарах ахуйн хог хаягдлыг Эрдэнэбулган сумтай гэрээ байгуулан тээвэрлүүлсэн. /Төлбөр төлсөн баримт хавсаргав/ Мөн байгальд шууд хаягдах хаягдлын хэмжээг багасгахын тулд эх үүсвэр дээр нь ялган ангилалт хийх хогийн савыг уурхайн хотхон байрлуулан, ялган ангилалт хийж, ажилчдад хог хаягдлын хор уршиг болон ялган ангилалтын үр ашгийн талаарх сургалт мэдээллийг өгч байсан. Манай компанийн бас нэг уриа бол цэвэр орчинд ажиллаж амьдрахыг мөрдлөг болгодог. Тийм ч учраас зөвхөн өөрийн талбайгаар зогсохгүй ойр орчмын хог хаягдалдаа дарагдсан байсан газрын бүх л ахуйн хатуу хог хаягдал болоод малын сэг зэмийг цэвэрлэх ажлыг нэгдсэн журмаар зохион байгуулсан бөгөөд энэ ажилдаа нутгийн иргэдийг татан оролцуулж цалин хөлсийг нь олгож ажилласан.

Мөн үйлдвэрлэл явуулж байгаа орчноо цэвэр цэмцгэр байлгах нь байгаль орчин төдийгүй хүний эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлыг хангах бөгөөд тав тухтай амьдрах орчныг давхар давхар бүрдүүлж өгдөг ач холбогдолтой билээ.

Хүснэгт 5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө болон биелэлт

№	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Ахуйн хог хаягдлаа орон нутагтай гэрээ байгуулан тээвэрлүүлэх	Үйлдвэрийн дарга, Байгаль орчны мэргэжилтэн	Орон нутагтай байгуулсан гэрээг хавсралтаа оруулав.
2.	Ахуйн хатуу хог хаягдал хаях сав байрлуулах		Хог хаягдлаа төрөлжүүлэн ангилах зориулалтын хогийн савыг байрлуулав. Зураг хастралтаар оруулав..

3.	Хатуу хог хаягдлын цэгийн гадна талд болон бусад орчинд хог алдагдахаас сэргийлэн хашаа барих	Хог хаядал орчинд тархахаас урьдчилан сэргийлж хатуу хог хаягдлаа газар дээр нь ялган ангилах ажил хийж байна.
----	---	--

Үйлдвэрлэл, үйл ажиллагаа тэр дундаа ажилчдын хоол боловсруулалтын явцаас гарах ахуйн хатуу хог хаягдлыг эх үүсвэр дээр нь буюу гарах гаралтын цэг дээр нь хангалттайхэмжээнд ялган ангилан хаях боломжит хогийн савнуудыг байршуулан ажилласан. Тус сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүн бодит болоход ажилчдын ухамсарт өөрчлөлт хийх үүднээс хог хаягдлын ялган ангилах сургалт, зааварчилгааг цаг тухай бүрт явуулан, ХАБ инженерэй хамтарсан. Ялган ангилалтаас гаран дахивар бүтээгдэхүүнийг боловсруулах, дахин ашиглах хувь хүн болон албан байгууллагад нийлүүлэн, ангилах боломжгүй хаягдлыг нэгдсэн хогийн цэг рүү ачиж байсан.



Зураг 23 Хог хаягдлыг ялган ангилах хогийн сав

8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Ашид бэхи” ХХК-иас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭНЖ” ЭЛС, ХАЙРГАНЫ
ХОЛИМГИЙН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАН БЕТОН ЗУУРМАГ ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН 2023
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Хяналт шинжил- гээний дээж	Хяналт шинжилгээний үзүүлэлт	Хяналт шинжил гээ явуулах хугацаа	Хяналт шинжилгээ явуулах байршил	Биелэлт
Агаар	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, NO ₂ . SO ₂ CO -ын агууламж,	Жилд 1 удаа	Уурхайн карьер, Уурхайн зам, Ажилчдын хотхон	Архангай аймгийн УЦУОШ-ний төв байгаль орчны шинжилгээний лабораториор шинжлүүлсэн.
Ус	Ажилчдын унд ахуйд ашигладаг усыг бактериологи болон ундны усны ерөнхий шаардлага,	Жил бүрийн 5 болон 8 дугаар саруудад	Унд ахуйн усны гүний худаг, цэврийн болон бохирын нуур	Архангай аймгийн УЦУОШ-ний төв байгаль орчны шинжилгээний лабораториор шинжлүүлсэн.
Хөрс	Хөрсний агрохими болон хүнд металлын шинжилгээ хийлгэх	Жилд 1- 2 удаа	- Овоолго - Кемп Хүнд металл: -ажилчдын ариун цэврийн байгууламж	Архангай аймгийн УЦУОШ-ний төв байгаль орчны шинжилгээний лабораториор шинжлүүлсэн.

9. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Болзошгүй аюул, осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэхээс сэргийлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Хүснэгт 6 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө болон биелэлт

№	Төлөвлөгөө	Биелэлт хариуцах эзэн	Биелэлт
1.	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хяналт тавьж байх /ажил эхлэхийн өмнө/	Механик инженер	ХАБ инженер болон механик инженер өглөө бүр ажил эхлэхийн өмнө техникийн үзлэг хийж аюулгүй байдлыг ханган ажиллаж байсан.
2.	Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	Компанийн захирал	Хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлын сургалтын зохион байгуулж байсан.

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭНЖ” ЭЛС, ХАЙРГАНЫ
ХОЛИМГИЙН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАН БЕТОН ЗУУРМАГ ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН 2023
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

3.	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	ХАБ инженер	Аюулгүй ажилагааны зааварчилгааг ажил эхлэхийн өмнө өдөр бүр ХАБ инженер өгч аюулгүй байдлаа ханган ажиллаж ирсэн.
4.	Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах	ХАБ инженер	Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулан орон нутгийн онцгой байдлын газраар дүгнэлт гаргуулсан.
5.	Хүчтэй салхи шуурганы үед уурхайн ажлыг түр зогсоох	ХАБ инженер	Салхи шуурга болон бороотой үед ажлыг түр зогсоож байсан.

**10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Уурхайн үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцаж ажиллана.

Хүснэгт 7 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө болон биелэлт

№	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх	Компанийн захирал Байгаль орчны мэргжилтэн	Байгаль орчны бодлого хөтөлбөр, хяналт шинжилгээ хийх журам, хог хаягдлын цуглуулах, хадгалах ажлын тухай заавар журмуудыг захирлаар батлуулж, ажилчдад танилцуулан дагаж мөрдөн ажиллаж байна.
2.	чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх		Байгаль орчныг хамгаалах ажилд /Хог хаягдал цэвэрлэх, мод тарих /нийт

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭНЖ” ЭЛС, ХАЙРГАНЫ
ХОЛИМГИЙН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАН БЕТОН ЗУУРМАГ ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН 2023
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

3.	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхижүүлэх уулзалт зөвлөгөөг жил бүр зохион		ажилчидтай хамтран ажилласан.
4.	байгуулах тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах		Хяналт шинжилгээний ажлын хүрээнд “Аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуй” сэдвээр ажилчдын дунд сургалт зохион байгуулж ажилчдынхаа

Хүснэгт 8 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн нийт зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийт зардал, төгрөг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	500,000
2	Тэрбум мод төслийн хүрээнд мод бут тарих	1,000,000
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	1,000,000
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	500,000
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	150,000
6	БОМТ-ий хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	300,000
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	845,000
Нийт		4,295,000

11. ДҮГНЭЛТ

2023 оны уулын ажлын төлөвлөгөөгөөр 78.54 мян.м3 элс-хайрга олборлон боловсруулах байснаас 32.52 мян.м3 элс-хайрга олборлож 8.61 мян.м3 бетон борлуулсан.

2023 оны БОМТөлөвлөгөөнд техникийн нөхөн сэргээлтийн ажил төлөвлөгдөөгүй боловч манай компани уурхайн карьерын хажууд байрлах хуучин эвдрэлд ороод орхигдсон газрын хог хаягдлыг цэвэрлэж, техникийн нөхөн сэргээлт хийсэн.

Техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 0.4 га талбайд хийхээр төлөвлөөд байсан бол **1.0 га** талбайд техникийн нөхөн сэргээлт хийж, биологийн нөхөн сэргээлтийн ажил төлөвлөгөөгүй болно.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Бүх нийтээр мол тарих өдөрлөгт оролцон, үйлдвэрлэлийн талбайд хайлаас, гүйлс, агч болон жимсний 500ш моддын тарилтыг хийж гүйцэтгэсэн.



**АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭНЖ” ЭЛС, ХАЙРГАНЫ
ХОЛИМГИЙН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАН БЕТОН ЗУУРМАГ ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН 2023
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ**

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Тусгай зөвшөөрлийн
Дугаар МУ55000035 (2022/001А)

Хөдөлгөөний Код Үйлчилгээний төрөл	Өөрчлөлт хөдөлгөөний тайлбар	Гарын үсэг, огмро, тамга
ТЗ олгосон	Аймгийн Засаг даргын 2022.05.16-ны өдрийн А/З39 дүгээр захирамжаар олгов. Анх олгосон хугацааг 2022.05.16-ны өдрөөр тооцно.	2022.05.23 
Төлбөр	Тусгай зөвшөөрлийн энхий жилийн төлбөр төлсөн.	2022.05.23 

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭНЖ” ЭЛС, ХАЙРГАНЫ
ХОЛИМГИЙН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАН БЕТОН ЗУУРМАГ ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН 2023
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ

Тусгай зөвшөөрлийн
Дугаар MV65080035 (2022001A)

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/	Хасагдах талбайн хэмжээ /га/	Тусгай зөвшөөрлийн талбайн солбилцлууд, огноо, гарын үсэг, тэмдэг		
				№	Уртраг	Өргөрөг
1	Тусгай зөвшөөрөл анх олгосон 2022.05.16	37.41	0	1.101° 30' 59.27"	47° 26' 58.55"	
				2.101° 30' 45.43"	47° 26' 55.13"	
				3.101° 30' 45.43"	47° 27' 22"	
				4.101° 31' 18.89"	47° 27' 22"	

Хавсралт 1 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭНЖ” ЭЛС, ХАЙРГАНЫ
ХОЛИМГИЙН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАН БЕТОН ЗУУРМАГ ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН 2023
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
ОРХОН-ЧУЛУУТ ГОЛЫН САВ
ГАЗРЫН ЗАХИРГАА

2 дугаар баг, Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139
Утас/Факс: (976) 7033 3764,

Цахим шуудан: orhonchuluut@gmail.com

10.03.09.19 № 97

танай _____-ны № _____-т

АШИД БЭХИ ХХК-Д

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т
заасны дагуу танай байгууллагын хаягдал усны
дүгнэлтийг гарган, хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт А хуудастай

ДАРГА



ЭТГОНБААТАР

ОРХОН-ЧУЛУУТ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА
ХАЯГДАЛ УСНЫ ДҮГНЭЛТ

2023.09.18

Дугаар АР-47

Эрдэнэбулган сум

Нэг. Ерөнхий мэдээлэл

- 1.1 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, захирлын нэр, утас факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар:
- Байгууллагын нэр: "Ашид Бэхи" ХХК
 - Дарга: П.Болортуяа
 - Харилцах утас: 88889978 Факс:
 - Улсын бүртгэлийн дугаар: 0111208103
 - Регистрийн дугаар: 3014231
- 1.2 Төслийн хаяг, байршил:
- Архангай аймгийн Эрдэнэбулган сум, 7-р баг. Хөгжлийн гудамж-1, Тамр-71, 7101А тоот, Орхон голын сав газарт хамаарч байна.

Хоёр. Хаягдал усны талаарх мэдээлэл

- 2.1 Хаягдал ус хаях цэгийн байршил, цэвэрлэгээний арга түвшин:
- "Ашид бэхи" ХХК нь унд ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг 3тн багтаамжтай бохир усны цооногт хуримтлуулаад улиралд 1 удаа "Ар Ус Ундарга" ХХК-ний ариутгах татуургын сүлжээнд нийлүүлдэг.
- 2.2 Хаягдал усны хэмжээ:
- Тус аж ахуй нэгж нь дулааны улиралд 4-н улиралд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 2023 оны хаягдал усны хэмжээг I улиралд 152,5 м³, II улиралд 500м³, III улиралд 500м³, IV улиралд 152,5м³ байхаар тооцов.
- 2.3 Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ, төрөл:
- БОАЖ-ын сайд, БХБ-ын сайдын хамтарсан 2019 оны А-816/218 тоот тушаалаар батлагдсан "Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээг"-г үндэслэн Органик бодис /химийн хэрэгцээт хүчилтөрөгч/-ын хэмжээг бусад үйлдвэрлэл 0.80кг/м³-ээр тооцно.

Гурав. Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ

3. Засгийн газрын 2019 оны 316 дугаар тогтоолоор батлагдсан "Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ, ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт болон хөнгөлөлтийн хувь хэмжээг тогтоох журам"-ын дагуу органик бодис 50 төг/кг -өөр тооцов.
- 3.2 Ус бохирдуулсны төлбөрийн тооцоо:

Ус бохирдуулсны 1-р улирлын төлбөрийн тооцоо:
Органик бодис /XXX/ $0,80\text{кг/м}^3 * 152,5\text{м}^3 = 122\text{кг}$
 $122\text{кг} * 50 \text{ төг} = 6,100$ / Зургаан мянга нэг зуун /төгрөг
Ус бохирдуулсны 2-р улирлын төлбөрийн тооцоо:
Органик бодис /XXX/ $0,80\text{кг/м}^3 * 500\text{м}^3 = 400\text{кг}$
 $400\text{кг} * 50 \text{ төг} = 20,000$ / Хорин мянган /төгрөг
Ус бохирдуулсны 3-р улирлын төлбөрийн тооцоо:
Органик бодис /XXX/ $0,80\text{кг/м}^3 * 500\text{м}^3 = 400\text{кг}$
 $400\text{кг} * 50 \text{ төг} = 20,000$ / Хорин мянган / төгрөг
Ус бохирдуулсны 4-р улирлын төлбөрийн тооцоо:
Органик бодис /XXX/ $0,80\text{кг/м}^3 * 152,5\text{м}^3 = 122\text{кг}$
 $122\text{кг} * 50 \text{ төг} = 6,100$ / Зургаан мянга нэг зуун / төгрөг

3.3 Ус бохирдуулсны төлбөрт: $6,100 + 20,000 + 20,000 + 6,100 = 52,500$ / Тавин хоёр
мянга таван зуун / төгрөг ногдож байна.

Дөрөв. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөмж

- 4.1 Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т заасны дагуу Эрдэнэбулган сумын Засаг даргаас хаягдал ус зайлуулах зөвшөөрлийн бичиг авч, төлбөрийн гэрээ байгуулах;
- 4.2 "Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. ерөнхий шаардлага MNS 6561:2015 стандартын шаардлагад нийцүүлэн зайлуулах, стандартаас давсан тохиолдолд Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, БОАЖ-ын сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар баталсан "Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам"-ын дагуу нөхөн төлбөр ногдуулахыг анхаарах;
- 4.3 Хаягдал усны дүгнэлтийг дараа оны эхний улиралд багтаан гаргуулах бөгөөд улирал бүр хоёроос доошгүй хаягдал усны сорьц авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн дараа сарын 15-ны дотор ирүүлж байх;
- 4.4 Ус бохирдуулсны төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлөх ба хугацаанд төлөөгүй бол Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээх нөхцөл үүсэхийг анхаарах;
- 4.5 Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 заасны дагуу усны мэдээллийн сав бүрдүүлэхэд шаардлагатай хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичиг хаягдал усны шинжилгээний дүгнэлтүүд төлбөр төлсөн баримтыг 2023 оны 12 дугаар сарын 10-ны дотор Орхон-Чулуут голын сав газрын захиргаанд ирүүлэх.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:
МЭРГЭЖИЛТЭН

ХЯНАСАН: ДАРГА



Д.МӨНХЦЭЦЭГ

Ч.ОТГОНБААТАР

Хавсралт 2 Хаягдал усны дүгнэлт

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭНЖ” ЭЛС, ХАЙРГАНЫ
ХОЛИМГИЙН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАН БЕТОН ЗУУРМАГ ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН 2023
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР
Чингүнжавын гудамж, 2 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16050
Утас/Факс: (976-51) 26 55 78, (976-51) 26 55 36,
Цахим шуудан: office@water.gov.mn,
Цахим хуудас: www.water.gov.mn


2023.02.06 № 05/137
танай 2023.01.24-ны № 2301/05 -т

“АШИД БЭХИ” ХХК-Д

Танай байгууллагын 2023 оны 2301/05 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлт, холбогдох бичиг баримтыг судалж үзээд Усны тухай хуулийн 28.4 дэх хэсэгт заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутагт орших түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглалтын MV-65000035 (2022/001A) дугаартай тусгай зөвшөөрөл бүхий “Дэнж” нэртэй газарт элс-хайрганы холимгийн ордыг ил аргаар ашиглах төсөл болон бетон зуурмагийн үйлдвэрт 2023 онд ус ашиглуулах дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хувийг Орхон-Чулуут голын сав газрын захиргаанд.

Хавсралт 4 хуудастай.

УС АШИГЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА  У.ӨЛЗИЙЦЭЦЭГ

162330291

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭНЖ” ЭЛС, ХАЙРГАНЫ
ХОЛИМГИЙН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАН БЕТОН ЗУУРМАГ ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН 2023
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2023 оны 02 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот
Утас: 51-265530

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, хаяг, утас факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар:

